

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/19/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг Төрийн Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: С.Гансүх
Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
4.1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.27 № 01/295
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
Б.ЭРДЭНЭНАРАН ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрдэнэбулган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэбулган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлсэнтэй холбоотой нийт хөрөнгийн хэмжээ 3,870.4 сая төгрөг болж 37.6 хувиар буурсан байна.

Аудитын гол асуудал

Эрдэнэбулган сумын Засаг даргын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч нь санхүүгийн албаны даргын ажлыг хавсран гүйцэтгэж байгаа нь дотоод хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүссэн байна.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэбулган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч Хөвсгөл аймгийн Засаг даргатай тайлант онд 18 чиглэлээр 105 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг 83.1 хувиар дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мян.төг)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,024,139.0	1,977,103.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	389,028.8	1,705,829.6
33	АВЛАГА	135,572.9	170,721.4
35	БАРАА МАТЕРИАЛ	494,537.3	95,552.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	5,000.0	5,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,177,011.9	1,893,338.3
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	6,000.0	0.0
37300	Урт хугацаат зээл	6,000.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,171,011.9	1,893,338.3
39200	Биет хөрөнгө	5,028,805.6	1,854,504.3
39300	Биет бус хөрөнгө	142,206.4	38,833.9
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,201,151.0	3,870,441.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	21,039.4	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21,039.4	0.0
41300	Өглөг	21,039.4	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,180,111.5	3,870,441.3
51	Засгийн газрын хувь оролцоо	6,180,111.5	3,870,441.3
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,039,253.6	493,398.1
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,039,253.6	493,398.1
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	192,461.2	192,461.2
51200	Хуримтлагдсан үр дүн	2,053,847.4	1,849,926.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,894,549.3	1,334,655.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,201,151.0	3,870,441.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мян.төг)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,613,234.37	2,857,290.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	483,445.2	1,986,599.4
110	Орлогын албан татвар	54,407.0	183,119.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	54,407.0	215,819.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-32,700.0
113	Хөрөнгийн албан татвар	29,657.4	39,383.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	399,380.8	1,764,096.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,382,012.2	75,988.5
120	Нийтлэг татварын бус орлого	1,382,012.2	75,988.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,747,776.9	794,702.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,589,266.7	1,327,467.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,589,266.7	1,327,467.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,317,114.1	1,270,216.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,855,269.5	420,653.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	249,131.6	52,868.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,367.5	156,397.9
2104	Хангамж, бараа материалын зардал	183,178.5	63,409.7
2105	Нормативт зардал	322,562.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,417.4	27,432.6
2107	Томилолт, зочны зардал	3,851.3	2,000.0

Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,894.3	337,833.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	548,442.0	209,621.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	272,152.6	57,250.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,023,967.6	1,529,823.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	208,411.8	3,785,791.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	815,555.8	-2,255,968.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мян.төг)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,545,821.3	2,850,391.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	483,445.2	1,986,599.4
110	Орлогын албан татвар	54,407.0	183,119.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	54,407.0	215,819.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-32,700.0
113	Хөрөнгийн албан татвар	29,657.4	39,383.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	399,380.8	1,764,096.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	14,311.6	81,528.6
1181	Газрын төлбөр	11,414.5	8,804.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	373,654.7	1,673,763.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	103,206.8	61,589.7
120	Нийтлэг татварын бус орлого	103,206.8	61,589.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,959,169.3	802,202.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,144,786.5	1,077,081.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,144,786.5	1,077,081.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,605,330.4	1,019,909.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,849,945.9	420,567.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	249,119.0	52,954.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,845.9	121,335.5
2104	Хангамж, бараа материалын зардал	116,719.1	55,354.0
2105	Нормативт зардал	134,526.9	1,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,331.3	48,917.6
2107	Томилолт, зочны зардал	4,597.7	2,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,664.0	268,230.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,580.6	49,050.0
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,539,456.1	57,172.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	401,034.8	1,773,310.5
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	594,034.7	343,509.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	594,034.7	343,509.7
2200	Дотоод эх үүсвэрээр	594,034.7	343,509.7
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-594,034.7	-343,509.7

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-113,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	113,000.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-192,999.9	1,316,800.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	582,028.7	389,028.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	389,028.8	1,705,829.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,364,555.7	5,364,555.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	46,228.3	46,228.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,410,784.0	5,410,784.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-46,228.3	-46,228.3
9	Тайлант үеийн үр дүн	815,555.8	815,555.8
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,180,111.5	6,180,111.5
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,180,111.5	6,180,111.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-53,701.9	-53,701.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,126,409.7	6,126,409.7
19	Тайлант үеийн үр дүн	-2,255,968.4	-2,255,968.4
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,870,441.3	3,870,441.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,354,703.5	1,283,901.7	-70,801.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,099,062.6	829,437.0	-269,625.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	811,458.7	794,202.2	-17,256.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	431,528.1	420,567.5	-10,960.6
210101	Үндсэн цалин	425,710.5	364,475.0	-61,235.5
210102	Нэмэгдэл	0.0	41,234.6	41,234.6
210104	Урамшуулал	5,817.6	14,857.9	9,040.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,325.5	52,954.3	-2,371.2
210201	Тэтгэврийн даатгал	37,738.4	36,464.5	-1,273.9
210202	Тэтгэмжийн даатгал	4,374.7	4,010.1	-364.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,539.3	3,208.0	-331.3
210204	Ажилгүйдлийн даатгал	879.3	802.0	-77.3
210205	Эрүүл мэндийн даатгал	8,793.8	8,469.7	-324.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,350.0	121,335.5	-14.5
210301	Гэрэл, цахилгаан	32,000.0	25,356.6	-6,643.4
210302	Түлш, халаалт	87,500.0	94,616.5	7,116.5
210303	Цэвэр, бохир ус	1,850.0	1,362.3	-487.7
2104	Хангамж, бараа материалын зардал	50,457.6	50,412.3	-45.4
210401	Бичиг хэрэг	6,600.0	6,747.7	147.7
210402	Тээвэр, шатахуун	27,430.8	27,430.8	0.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,470.8	4,364.8	-106.0
210404	Ном, хэвлэл	400.0	313.0	-87.0

Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,660.5	7,660.5	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,895.5	3,895.5	0.0
2105	Нормативт зардал	1,500.0	1,500.0	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500.0	1,500.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,202.6	50,962.6	-240.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,550.0	2,550.0	0.0
210602	Тавилга	0.0	0.0	0.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000.0	1,000.0	0.0
210604	Урсгал засвар	47,652.6	47,412.6	-240.0
2107	Томилолт, зочны зардал	2,000.0	2,000.0	0.0
210702	Дотоод албан томилолт	2,000.0	2,000.0	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,894.9	47,270.1	-3,624.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,530.6	46,006.0	-3,524.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100.0	0.0	-100.0
210803	Даатгалын үйлчилгээ	77.5	77.4	-0.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	282.3	282.3	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75.0	75.0	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500.5	500.5	0.0
210807	Газрын төлбөр	329.0	328.9	-0.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,200.0	47,200.0	0.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,500.0	45,500.0	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,700.0	1,700.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	287,603.9	35,234.8	-252,369.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	252,367.9	0.0	-252,367.9
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	252,367.9	0.0	-252,367.9
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.0	0.0	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,236.0	35,234.8	-1.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000.0	1,000.0	0.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313.2	6,313.2	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,322.8	22,322.8	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,600.0	5,598.8	-1.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	105,640.9	341,464.7	235,823.8
223001	Бусад хөрөнгө	105,640.9	341,464.7	235,823.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150,000.0	113,000.0	-37,000.0
230001	Эргэж төлөгдөх зээл	150,000.0	113,000.0	-37,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,354,703.5	1,190,383.9	-164,319.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	167,319.5	174,819.5	7,500.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	167,319.5	174,819.5	7,500.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	800,552.1	992,044.2	191,492.1
320001	Орон нутгийн төсвөөс	800,552.1	992,044.2	191,492.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	386,831.9	23,520.3	-363,311.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,000.0	19,204.8	-20,795.2
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,650.0	4,315.5	-334.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	342,181.9	0.0	-342,181.9
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.0	0.0	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	135,775.1	135,775.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	42,257.3	42,257.3

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2021 он	2022 он	Зөрүү
II	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	214,040.2	208,344.9	-5,695.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	214,040.2	208,344.9	-5,695.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	156,648.2	206,008.9	49,360.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,507.0	0.0	-43,507.0
210101	Үндсэн цалин	3,557.4	0.0	-3,557.4
210102	Нэмэгдэл	39,949.6	0.0	-39,949.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,477.7	0.0	-5,477.7
210201	Тэтгэврийн даатгал	3,733.5	0.0	-3,733.5
210202	Тэтгэмжийн даатгал	435.0	0.0	-435.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	354.6	0.0	-354.6
210204	Ажилгүйдлийн даатгал	86.7	0.0	-86.7
210205	Эрүүл мэндийн даатгал	867.9	0.0	-867.9
2104	Хангамж, бараа материалын зардал	38,871.8	1,454.8	-37,417.0
210401	Бичиг хэрэг	665.0	0.0	-665.0
210402	Тээвэр, шатахуун	6,733.6	1,424.8	-5,308.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.0	30.0	30.0
210404	Ном, хэвлэл	2,174.0	0.0	-2,174.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	625.6	0.0	-625.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,673.6	0.0	-28,673.6
2105	Нормативт зардал	45,205.5	0.0	-45,205.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,620.5	0.0	-43,620.5
210502	Хоол, хүнс	1,585.0	0.0	-1,585.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,195.5	202,704.1	183,508.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,195.5	202,704.1	183,508.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,390.8	1,850.0	-2,540.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,077.4	0.0	-4,077.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	313.4	1,850.0	1,536.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,392.0	2,336.0	-55,056.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,392.0	2,336.0	-55,056.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	57,392.0	2,336.0	-55,056.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	0.0	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0	0.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	214,040.2	208,344.9	-5,695.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	214,040.2	208,344.9	-5,695.3
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	600.0	0.0	-600.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	202,930.8	202,930.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	210,023.9	5,239.1	204,784.7
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,416.4	175.0	-3,241.4
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Эрдэнэбулган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Хүний хөгжлийг эрхэмлэн дээдэлсэн байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангасан тогтвортой ногоон эдийн засаг бүхий загвар сум болох” зорилгыг дэвшүүлэн ажилласан байна. Дээрх зорилгыг хэрэгжүүлэхээр тайлант онд 18 чиглэлээр 105 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тус сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 83.1 хувиар дүгнүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй. Тус төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нийт 2 байгууллага, орон нутгийн 2 сан, Ерөнхий орлогын данс, Эрдэнэбулган дулаан ХХК-ийн санхүүгийн тайлан, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн хаалтын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулжээ. Засгийн газрын 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийг улсын төсөвт шилжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас нэгдсэн байдлаар боловсруулан мөрдүүлж байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд томоохон өөрчлөлт ороогүй байна. Тайлант онд шинээр Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлсэн.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгжийг Засаг даргын 2021 оны А/78 тоот захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх дотоод хяналтын нэгжийн хяналт шалгалт явуулах журмыг сумын Засаг даргын 2017 оны А/21 захирамжаар баталсан байна.

Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгжийг Засаг даргын 2021 оны 04 сарын 06-ны өдрийн А/48 тоот захирамжаар

5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Дотоод хяналтын нэгж нь тайлант онд нийт 5 ажил хийхээр төлөвлөж хяналт шалгалтыг зохион байгуулж үр дүнг тайлагнаж ажилласан байна. Хяналтаар илэрсэн зөрчилд холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Дотоод хяналтын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын нэгжийн гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын нэгжээс шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-д нийцүүлэн нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ. Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэбулган сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 3,870.4 сая төгрөг болж өмнөх оноос 2,330.7 сая төгрөгөөр буурсан нь байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	389.2	1,705.8	1,313.8
Авлага	135.6	170.7	35.1
Бараа материал	494.5	95.6	-389.9
Бусад эргэлтийн хөрөнгө	5.0	5.0	0.0
Урт хугацаат хөрөнгө оруулалт	6.0	0.0	-6.0
Үндсэн хөрөнгө	5,171.0	1,893.4	-3,277.6
Нийт хөрөнгө	6,201.02	3,870.4	-2,330.8
Өр төлбөр	21.0	0.0	-21.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,180.1	3,870.4	-2,309.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,201.2	3,870.4	-2,330.7

Эх сурвалж: Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө, бараа материал данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө 1,313.8 сая төгрөгөөр өсөхөд орон нутгийн орлого давж биелсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.
- Авлага 35.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2022 онд хоршоо болон ахуйн нэгжүүдэд 113 сая төгрөгийн зээл олгосонтой холбоотой байна. Үүнээс 15 иргэн, аж ахуйн нэгжийн 51.1 сая төгрөгийн зээл, хүүгийн авлагын хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй ба шүүхээр шийдвэрлүүлэх шатанд шатанд явж байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 389.9 сая төгрөгөөр буурахад "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн

ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хөрөнгө шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Үүнд: Соёлын төвийн 14.5 сая төгрөг, Ерөнхий боловсрол сургуулийн 173.0 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн 85.3 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгийн 147.7 сая төгрөгийн материал шилжүүлсэн байна.

- Урт хугацаат хөрөнгө оруулалт 6.0 сая төгрөгөөр буурч 0.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,277.6 сая төгрөгөөр буурахад "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Үүнд Соёлын төвийн 107.7 сая сая төгрөг, Ерөнхий боловсрол сургуулийн 2,328.0 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн 273.5 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгийн 656.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотойгоор буурсан байна.
- Өр төлбөрийн үлдэгдэл байхгүй
- Орон нутгийн өмч 2,330.7 сая төгрөгөөр буурахад "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хөрөнгө шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 2,857.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 1,755.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №9 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	483.4	1,986.6	1,503.2	310.9
Татварын бус орлого	1,382.0	76.0	-1306.0	-94.5
Тусламж санхүүжилтийн орлого	2,747.8	794.7	-3,217.8	-117.1
Нийт дүн	4,613.2	2,857.3	-1,755.9	-38.1

Эх сурвалж: Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын тайлан улсын төсөвт шилжсэнтэй холбоотойгоор үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, санхүүжилтийн орлого зэрэг нь нөлөөлсөн байна. Мөн татварын орлого өссөн нь ойн нөөц ашигласны төлбөрийн орлого давж биелсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын хоорондын тооцоогоор 1,191.1 сая төгрөгийн орлогын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 5,113.3 сая төгрөгийн зардал тайлагнасан байна.

Хүснэгт №10: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал	3,589.3	1,327.5	-2,261.8	-63.0
Үйл ажиллагааны бус зардал	208.4	3,785.8	3,577.4	1,719.9
Нийт дүн	3,797.7	5,113.3	1,315.6	34.6

Эх сурвалж: Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан

Нийт зардлын дүн өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалыг шилжүүлэхдээ үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын хоорондын тооцоогоор 1,191.1 сая төгрөгийн зарлагын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Эрдэнэбулган сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 1,440.8 сая төгрөгийн төсөв баталснаас 981.6 сая төгрөгийг урсгал зардалд, 346.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, зээл олгоход 113.0 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 356.6 сая төгрөгийг орон нутгийн орлогоос, 207.1 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 587.8 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 176.3 сая төгрөгийг давсан орлого дансны үлдэгдлээс, 113 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлогоос тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Эрдэнэбулган сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 01 дугаар тогтоолоор төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэгийг 168.0 сая төгрөгийн хасах тодотгол хийж төсвийг 419.9 сая төгрөгөөр баталсан байна. Мөн хавсралтаар орон нутгийн ерөнхий орлогын дансны 2021 оны үлдэгдэл, давсан орлого 75.5 сая төгрөгийг нэмж баталсан. Хасах тодотгол хийсэн нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагад ажиллагсдын цалинг улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Гүйцэтгэлээр мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 135.8 сая төгрөг дээр орон нутгийн төсвийн санхүүжилт 1,017.5 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 19.2 сая төгрөг, хүүгийн эргэн төлөлт 4.3 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас 174.8 сая төгрөгийн санхүүжилтийн орлого орж, 1,283.9 сая төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 25.4 сая төгрөг төвлөрүүлж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 42.3 сая төгрөг байна. Төсвийн орлого бүрдүүлэлтийг харуулбал:

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Эрдэнэбулган сумын ИТХ-ын 2022 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолд зааснаар Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 356.6 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 652.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 138.6 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №11. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	9.2	10.7	1.5	116.9
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	145.0	168.6	23.6	116.3
Хөрөнгийн орлого	30.0	27.5	-2.4	91.8
Хөрөнгө борлуулсны орлого	1.7	3.5	1.7	201.3
Шууд бус орлого	9.2	5.4	-3.8	58.7
ХХОАТ-ын буцаан олголт	-32.7	-32.7	0.0	100.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	8.7	9.3	0.6	107.1
Бууны албан татвар	5.5	6.2	0.6	112.4
Малд ногдуулах албан татвар	24.9	23.9	-1.0	95.9
Улсын тэмдэгтийн хураамж	8.0	62.9	61.2	865.5
Түгээмэл тархацтай ашигт малтал	1.3	5.2	3.8	387.7

Хог хаягдлын хураамж	7.7	7.1	-0.6	92.9
Газрын төлбөр	10.0	8.8	1.5	88.0
Ойн нөөц ашигласны төлбөр	132.8	1,651.9	1,519.0	1,243.4
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	11.2	19.8	8.6	177.5
Ус рашаан ашигласны төлбөр	0.7	0.4	-0.3	61.4
Байгалын ургамал ашигласны төлбөр	1.6	1.6	0.0	100.0
Торгуулийн орлого	6.7	6.4	-0.3	96.1
НИЙТ	381.5	1,993.0	1,611.5	522.4

Эх сурвалж: Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Сумын орон нутгийн орлого 1,611.5 сая төгрөгөөр давж биелэхэд Эрдэнэбулган суманд самар ургасантай холбоотой Ой ашигласны төлбөр 1,519.0 сая төгрөг давж биелсэн ба үүнтэй холбоотой улсын тэмдэгтийн хураамж 61.2 сая төгрөгөөр тус тус биелсэн нь орон нутгийн орлого давахад гол хүчин зүйл зүйл болон нөлөөлсөн. Орон нутгийн орлогоос 7 нэр төрлийн 5.5 сая төгрөгийг орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Орон нутгийн төлөвлөгөө биелээгүй орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Хөрөнгийн орлого 2.4 сая төгрөг, шууд бус орлого 3.8 сая төгрөг, малд ногдуулах албан татвар 1.0 сая төгрөг, хог хаягдлын хураамж 0.5 сая төгрөг, газрын төлбөр 1.2 сая төгрөг, ус рашаан ашигласны төлбөр 0.3 сая төгрөг, торгуулийн орлого 0.3 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 3.2 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 27.2 сая төгрөгөөр төлөвлөж 24.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 88.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №12: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ААНОАТ	13.7	1.9	-11.8
2	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	10.5	19.8	9.2
3	Зам ашигласны төлбөр	3.0	3.3	0.3
	Нийт дүн	27.2	24.9	2.3

Эх сурвалж: Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар 9.2 сая төгрөг, зам ашигласны төлбөр 0,3 сая төгрөгийг тус тус давж биелүүлсэн байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төлөвлөгөөгөө 11.8 сая төгрөгөөр тасарсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 11.5 сая төгрөгөөр төлөвлөж 9.3 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 2.2 сая төгрөгөөр тасарсан 80.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №13: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	7.5	4.6	-2.8
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	3.2	2.9	-0.3
3	Агаарын бохирдлын төлбөр	0.8	1.7	0.8
	Нийт дүн	11.5	9.3	-2.2

Эх сурвалж: Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төлөвлөгөө 2.2 сая төгрөг, НӨАТ-ын албан татварын төлөвлөгөө 0.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 1,354.7 сая төгрөгөөр төлөвлөж, 1,190.4 сая төгрөг буюу 87.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 44.6 сая төгрөгийг орлогыг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 23.5 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлтийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 1,354.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,099.1 сая төгрөгийг урсгал зардалд, 358.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 150.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 829.4 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 341.5 сая төгрөгийг, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд 113.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,283.9 сая төгрөг буюу 94.8 хувьтай байгаа нь Сангийн яамнаас тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүйтэй холбоотой байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 11.0 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.4 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 3.6 сая төгрөг

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

ИТХ-ын 2021 оны 12 сарын 17-ны №03-р тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах 7 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс шилжих хөрөнгө оруулалтаар чанарын баталгаа олгох 1, шинээр эхлэх хөрөнгө оруулалт 6 нийт 252.4 сая төгрөгийн төсөв баталсан.

Гүйцэтгэлээр төлөвлөсөн ажлууд бүрэн хэрэгжсэн байна.

Сум хөгжүүлэх сангийн талаар:

Эрдэнэбулган сумын ИТХ-ын тогтоолоор Сум хөгжүүлэх сангийн 2022 оны санхүүжилтийг 150.0 сая төгрөг байхаар баталсан. Тайлант онд нийт 113.0 сая төгрөгийн зээл олгож, зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтад 1.9 сая төгрөгийг зарцуулж, зээлийн эргэн төлөлтөөс 23.5 сая төгрөг, хүүгийн орлогоос 4.3 сая төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар байгаль орчны аялал жуулчлалын газраас хогийн цэг нүүлгэн шилжүүлэх далан барих ажлын эрх шилжсэн 200 сая төгрөг, тендерийн орлого 0,2 сая төгрөг, статистикийн хэлтсээс мал тооллогын зардал 2.9 сая төгрөг, аймгийн ИТХ-аас хамтарсан багийн үйл ажиллагааны зардалд 300.0 мянган төгрөг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 2.2 сая төгрөг, Шилдэг ИТХ-ын шагнал 0.6 сая төгрөг, Хууль зүйн яамны гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх төслөөс 2.1 сая төгрөг тус тус орж ирсэн. Гүйцэтгэлээр бараа үйлчилгээний зардалд 208.3 сая төгрөгийг зарцуулжээ. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэбулган сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Эрдэнэбулган сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 1/74 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,254.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 45.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 36.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж материаллаг түвшнийг 28.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг түвшнийг 22.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,511.6 сая төгрөг буюу 90.8 хувьтай байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 6.4 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.3 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 7.8 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 9.4 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 5.2 сая төгрөг
- Урсгал шилжүүлгийн зардал 93.9 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Эрдэнэбулган сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд 3 зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	2.9	3	2.9	100
Нийт дүн	3	2.9	3	2.9	100

Өмнөх онд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 71.5 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрсэн. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой 1, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой 1, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах 1, дотоод хяналт хариуцлагатай холбоотой 1 нийт 4 зөвлөмж хүргүүлж байна

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлогын данс болон харьяа төсвийн 2 байгууллага, орон нутгийн өмчит 1 аж ахуйн нэгж, орон нутгийн 2 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, бусад байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлын хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан ЗДТГ-ын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 39.8 сая төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрсэн. Аудитын хугацаанд 39.8 сая төгрөгийн 2 зөвлөмжийг өгсөн байна.

5.1 Төлбөрийн акт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Улс, аймаг, сумын орлогын төлөвлөгөөнөөс 10 нэр төрлийн 20.4 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр биелүүлж ажиллах.

2. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар

2.1. Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 39.8 сая төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрсэн. Аудитын хугацаанд 39.8 сая төгрөгийн 2 зөвлөмжийг өгсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжүүдийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах

3. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлсэн сангийн 15 иргэн, аж ахуйн нэгжийн 51.1 сая төгрөгийн зээл, хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоо хөгжүүлэх сангийн журам"-ын 3.4.11. Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1. Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хоцорсон зээл, хүүгийн үлдэгдлийг төвлөрүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх

4. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч нь Санхүүгийн албаны даргын үүргийн хавсран гүйцэтгэж байгаа нь Нийтийн албанд нийтийн болон болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1 "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт

хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна

4.1. Өгсөн зөвлөмж:

Төсөвт байгууллагын нягтлан бодогчоор Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтний үүргийг хавсран гүйцэтгүүлэхгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4.1 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд 1.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2.8 сая төгрөгийн 2 зөвлөмжийг өгсөн байна.	1						1					
Улс, аймаг, сумын татварын орлогын төлөвлөгөөнөөс 10 нэр төрөл дутуу биелсэн.	1	20.4					1	20.4				
Хоршоо хөгжүүлсэн сангийн зээлээс 15 иргэн, аж ахуйн нэгжийн 51.1 сая төгрөгийн зээл, хүүгийн авлага хугацаа хэтэрсэн байна.	1	51.1					1	51.1				
Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч нь Санхүүгийн албаны даргын үүргийн хавсран гүйцэтгэж байна	1						1					
Дүн	4	71.5					4	71.5				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Эрдэнэбулган сумын Засаг даргын Тамгын газар	2	39.5					2	39.5				
Дүн	2	39.5					2	39.5				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 БАТАЛГААЖУУЛСАН:
 АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО: 11/24
 Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО: 11/24
 С.ГАНСҮХ ОГНОО: 24/11